

МОНГОЛ УЛСЫН ТӨЛБӨРИЙН СИСТЕМ

ОРШИЛ.....	3
1. ЕРӨНХИЙ БҮТЭЦ	4
1.1 Хууль, эрх зүйн орчин.....	4
1.1.1. Хяналт тавих эрх бүхий байгууллага	4
1.1.2. Хууль, эрх зүйн баримт бичгүүд.....	5
1.2. Төлбөрийн систем дэх Төв банк (Монголбанк)-ны оролцоо.....	6
1.2.1. Мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах	6
1.2.2. Мөнгөний бодлого	6
1.2.3. Банкны хяналт, шалгалт	7
1.2.4. Төлбөрийн системийн бодлого, зохицуулалт ба хяналт	7
1.2.5. Үйлчилгээний нөхцөл	7
1.3.Төлбөрийн систем дэх бусад байгууллагын оролцоо	8
1.3.1. Банкууд.....	8
1.3.2. Сангийн яамны Төрийн сангийн газар (Төрийн сангийн газар).....	9
1.3.3. Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв (ҮЦГТТХТ)	9
1.3.4. Банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)	9
1.3.5. Хадгаламж, зээлийн хоршоо (ХЗХ).....	10
1.3.6. Үндэсний цахим гүйлгээний төв (ҮЦГТ)	10
1.3.7. Монголын банкны холбоо (МБХ).....	10
2. ТӨЛБӨРИЙН ХЭРЭГСЭЛ.....	10
2.1.Бэлэн мөнгө	10
2.2. Бэлэн бус төлбөрийн хэрэгсэл.....	11
2.2.1.Бэлэн бус төлбөрийн хэрэгсэл.....	11
2.2.1.1. Кредит шилжүүлэг	11
2.2.1.2. Дебит шилжүүлэг	11
2.2.1.3. Чек.....	11
2.2.1.4. Төлбөрийн картын төлбөр тооцоо	11
2.2.1.5. Урьдчилсан төлбөрт карт (цахим мөнгө).....	12
2.2.1.6. Мобайл банкны үйлчилгээ	12
2.2.2. Бэлэн бус төлбөр тооцооны төхөөрөмж	13
2.2.2.1. АТМ төхөөрөмж	13
2.2.2.2. ПОС, ПОБ терминал	13
2.2.2.3. Интернет банк.....	13
2.2.3. Бусад	13

3. ТӨЛБӨРИЙН СИСТЕМ.....	14
3.1. Ерөнхий танилцуулга	14
3.2. Их дүнтэй төлбөр тооцооны “Банксүлжээ” систем.....	14
3.2.1. Үйл ажиллагааны заавар, журам.....	15
3.2.2. Системийн оролцогч	15
3.2.3. Гүйлгээний төрөл	15
3.2.4. “Банксүлжээ” системийн үйл ажиллагаа	15
3.2.5. “Банксүлжээ” системээр төлбөр тооцоо гүйцэтгэх.....	16
3.2.6. Эрсдэлийн удирдлага	16
3.2.7. Төлбөр тооцооны шимтгэл.....	16
3.3. Бага дүнтэй төлбөр тооцооны систем.....	17
3.3.1. Үйл ажиллагааны заавар, журам.....	17
3.3.2. Системд оролцогч.....	17
3.3.3. Төлбөр тооцоо.....	17
3.3.4. Үйл ажиллагаа	17
3.3.5. Эрсдэлийн удирдлага	18
3.3.6. Төлбөр тооцооны шимтгэл.....	18
3.4. Төлбөрийн картын систем	18
3.4.1. Үйл ажиллагааны заавар, журам.....	19
3.4.2. Системд оролцогч.....	19
3.4.3. Үйл ажиллагаа	19
3.4.4. Үр дүнгийн тооцоолол.....	19
3.4.5. Эрсдэлийн удирдлага	20
3.4.6. ”Картын нэгдсэн сүлжээ”-ний шимтгэл.....	20
3.5 Гадаад валютын хил дамнасан гуйвуулгын систем	21
4. ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨР ТООЦОО, ҮР ДҮНГИЙН ТООЦООЛОЛ.....	21
4.1. Ерөнхий зүйл.....	21
4.2. Хамрах хүрээ.....	22
4.2.1. Эрсдэлийн удирдлага	22
4.3. Үнэт цаасны төрөл.....	22
4.3.1. Засгийн газрын үнэт цаас (ЗГҮЦ) ба Төв банкны үнэт цаас (ТБҮЦ).....	22
4.3.2. Аж ахуйн нэгжийн хувьцаа	22
4.4. Үнэт цаасны арилжаа ба үр дүнгийн тооцоолол	22
4.4.1. Засгийн газрын үнэт цаас	22
4.4.2. Төв банкны үнэт цаас	23
4.4.3. Аж ахуйн нэгжийн хувьцаа	23

О Р Ш И Л

Монгол Улсын Банкны тухай хуулийг 1991 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр батлан гаргаснаар Монгол Улсад Төв банк, арилжааны банк гэсэн 2 шатлал бүхий банкны систем бүрэлдэн тогтсон билээ. Энэ үеэс Монголбанк нь банк хоорондын төлбөр тооцоог зохион байгуулж эхэлсэн бөгөөд Монголбанкны хариуцах үүргийг 1996 оны 9 дүгээр сарын 3-ны өдөр баталсан Төв банкны тухай хуулиар баталгаажуулсан юм.

Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль 1995 онд батлагдсанаар төлбөр тооцоог төлбөрийн даалгавар, төлбөрийн нэхэмжлэл, аккредитив, чек, вексель, төлбөрийн карт зэрэг бэлэн бус төлбөрийн хэрэгслээр гүйцэтгэх болсон. Монголбанк нь арилжааны банкуудын нягтлан бодох бүртгэлийн хариуцлагыг өндөржүүлэх зорилгоор банкуудын төвийг нэгдсэн цахим сүлжээнд холбож, банк хоорондын клирингийн тооцооны журмыг 1997 онд шинээр баталсан. Түүнчлэн, Монголбанк нь олон улсын төлбөр тооцооны СВИФТ¹ сүлжээнд холбогдсоны үр дүнд гадаад төлбөр тооцоог шуурхай дамжуулах боломжтой болж, гадаад орнуудтай хийх төлбөр тооцооны найдвартай байдлыг хангасан билээ.

Төлбөрийн системийг шинэчлэх ажлын хүрээнд 2006 онд одоогийн Үндэсний цахим гүйлгээний төв (ҮЦГТ гэх)-ийг байгуулж, банкуудын төв, Сангийн яамны Төрийн сангийн газар, Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв (ҮЦТТТХТ)-ийг санхүүгийн дундын сүлжээгээр дамжуулан ҮЦГТ-тэй холбогдох боломжийг бүрдүүлсний үр дүнд эдгээр оролцогчид өөрсдийн төлбөр тооцоог бодит цагийн горимоор дамжуулж, хянах боломжтой болсон. Уг системийн үйл ажиллагааг зохицуулах зорилгоор Монголбанкнаас 2006 онд “Банк хоорондын их дүнтэй төлбөр тооцооны журам”, “Банк хоорондын бага дүнтэй төлбөр тооцооны журам”-ыг тус тус батлан гаргасан. Банк хоорондын төлбөр тооцоог их, бага дүнгээр нь ялган зохицуулсан нь Монгол Улсын төлбөрийн системийн үр ашигтай, найдвартай байдлыг бэхжүүлэхэд чухал алхам болсон.

Монголбанк нь банк хоорондын их дүнтэй төлбөр тооцоог бодит цагт дамжуулах “Банксүлжээ” системийг 2009 онд, нэвтрүүлсэн нь төлбөрийн мэдээллийн бүрэн бүтэн байдал, нууцлал аюулгүй байдлыг хангасан төдийгүй харилцах дансдын үлдэгдлийг тухай бүрт нь хянах боломжийг төлбөрийн системийн нийт оролцогчдод олгосон ач холбогдолтой юм. Ингэснээр банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадвар нэмэгдэж, нөөц эх үүсвэрээ үр ашигтай удирдах боломжтой болсон билээ.

Монгол Улсын төлбөрийн системийн үр ашигтай, найдвартай байдлыг бэхжүүлэх зорилгоор төлбөрийн системийн хяналтыг хэрэгжүүлэхтэй холбоотой хууль, эрх зүйн орчинг бүрдүүлэхээр ажиллаж байна.

¹ Олон улсын банк санхүүгийн байгууллагын хооронд санхүүгийн мэдээг дамжуулдаг цахим сүлжээ.

1. ЕРӨНХИЙ БҮТЭЦ

1.1 Хууль, эрх зүйн орчин

Монгол Улсын төлбөрийн системд Төв банк (Монголбанк), банкууд, Сангийн яамны Төрийн сангийн газар, Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв гэсэн байгууллагууд шууд оролцогч байна. Харин банк бус санхүүгийн байгууллага нь банкаар дамжуулан шууд бус хэлбэрээр оролцож байна.

Монгол Улсын банкны системийн үйл ажиллагааны хууль, эрх зүйн гол баримт бичиг нь Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, Банкны тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, актууд юм.

1.1.1. Хяналт тавих эрх бүхий байгууллага

Төв банк (Монголбанк)

Монгол Улсын Төв банк (Монголбанк)-ны тухай хууль 1996 оны 9 дүгээр сарын 3-ны өдөр батлагдаж, шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг хэд хэдэн удаа оруулж, хамгийн сүүлд 2013 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр Хадгаламжийн даатгалын корпорацийн үйл ажиллагаатай холбоотой заалтуудыг нэмж оруулсан. Монголбанк нь үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн тогтвортой байдлыг хангах үндсэн зорилтынхоо хүрээнд санхүүгийн зах зээл, банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах замаар үндэсний эдийн засгийн тэнцвэртэй хөгжилд дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэй. Монголбанкны төв салбар нь Улаанбаатар хотод байрлах ба орон нутагт 15 салбар, 2 хэлтэстэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)

СЗХ нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах нэгдсэн бодлого боловсруулж, банк бус санхүүгийн, даатгалын, хоршооны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа, үнэт цаасны зах зээл, хуульд заасан санхүүгийн бусад харилцаанд оролцогчдын үйл ажиллагааг зохицуулах, хянах чиг үүрэгтэй.

Төлбөр тооцооны үндэсний зөвлөл (ТТҮЗ)

Монгол Улсын төлбөрийн системийн оролцогчдын ашиг сонирхлыг нэгтгэх, хамтын ажиллагааг дэмжих замаар үндэсний төлбөр тооцооны системийг хөгжүүлэх зорилготойгоор Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайд, СЗХ-ны даргын 2008 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн хамтарсан тушаалаар ТТҮЗ-ийг байгуулсан. Зөвлөлийн гишүүдэд Монголбанк, банкууд, Монголын банкны холбоо (МБХ), Сангийн яамны Төрийн сангийн газар (ТСГ), СЗХ, Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв (ҮЦТТТХТ), Монголын хөрөнгийн бирж (МХБ), Харилцаа холбооны зохицуулах хороо тус тус багтдаг.

ТТҮЗ нь Монгол Улсын төлбөрийн системийн үр ашигтай, найдвартай ажиллагааг хангах зорилгоор “Монгол Улсын төлбөрийн системийг 2009-2014 онд хөгжүүлэх дунд хугацааны стратеги”-ийг баталсан.

1.1.2. Хууль, эрх зүйн баримт бичгүүд

Банк, санхүүгийн салбарын эрх зүйн орчинг бэхжүүлэх үүднээс олон тооны хууль тогтоомж, зохицуулалтын баримт бичгүүд батлагдсан.

1996 оны 9 дүгээр сарын 3-ны өдөр батлагдсан Төв банкны тухай хуулиар Төв банк (Монголбанк)-ны бүрэн эрх, түүний удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлж, төрийн мөнгөний бодлогыг Төв Банк (Монголбанк)-наас хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулж байна. Тус хуулинд 2010 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр нэмэлт өөрчлөлт орсноор Монголбанкнаас хэрэгжүүлж буй мөнгөний бодлого болон банкны хяналт, шалгалтын аргачлал илүү тодорхой болсон.

Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль 1995 оны 10 дугаар сарын 31-ний өдөр батлагдаж, хожим 2011 оны 12 дугаар сарын 15-ны өдөр нэмэлт, өөрчлөлт орсон. Энэхүү хуулиар банкны төлбөр тооцоо, хадгаламж, зээлийн үйл ажиллагааг зохицуулдаг.

Векселийн тухай хууль 1995 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр батлагдаж, улмаар хувь хүн, хуулийн этгээд векселийг ашиглахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулж байна.

Банкны тухай хууль 1991 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр батлагдсан, 2010 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр уг хуулинд нэмэлт, өөрчлөлт орсон. Энэхүү хуулиар банк байгуулах зөвшөөрөл олгох, түүнийг хүчингүй болгох, банкны удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны үндсэн зарчмыг тогтоох, банк болон банкны нэгдлийн үйл ажиллагаанд хяналт тавих, тэдгээрт албадлагын арга хэмжээ авахтай холбогдсон харилцааг зохицуулна.

Хоршооны тухай хууль 1998 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр баталж, 2002 оны 12 дугаар сарын 12-ны өдөр “Хоршооны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа” гэсэн VI бүлгийг нэмж баталсан. Уг хуулийн 48.1-4 дүгээр заалтад “зээлийн хоршоо нь СЗХ-оос тусгай зөвшөөрөл авсны үндсэн дээр хадгаламж, зээлийн үйлчилгээг үзүүлнэ” гэсэн заалт нь 2011 оны 10 дугаар сарын 27-ны өдөр шинэчлэгдэн батлагдсан Хадгаламж зээлийн хоршооны тухай хууль гарснаар хүчингүй болсон байна.

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль 2002 оны 12 дугаар сарын 12-ны өдөр батлагдсан. Тус хуулинд “банк бус санхүүгийн байгууллага нь төлбөр тооцооны хэрэгсэл гаргах, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, гадаад валютын арилжаа” зэрэг үйл ажиллагааг эрхэлж болох ба энэ үйл ажиллагаатай холбогдсон төлбөр тооцоог банкаар зуучлуулж банк хоорондын төлбөр тооцоонд шууд бус оролцогчийн үүрэг гүйцэтгэхээр тусгагдсан.

СЗХ-ны эрх зүйн байдлын тухай хууль 2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр батлагдсан. Тус хуулийн дагуу СЗХ нь банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах эрх бүхий байгууллага байхаар тодорхойлсон.

“Төлбөрийн системийн оролцогч хоорондын их дүнтэй төлбөр тооцооны журам” 2013 оны 3 дугаар сарын 11-ний шинэчлэгдэн батлагдаж, улмаар анх 2007 оны 2 дугаар сарын 12-ны өдөр батлагдсан хувилбар хүчингүй болсон.

“Банк хоорондын бага дүнтэй төлбөр тооцооны журам” 2007 оны 2 дугаар сарын 12-ны өдөр батлагдаж улмаар Монголбанкны Ерөнхийлөгчийн 2011 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 245 дугаар тушаалаар шинэчлэгдсэн.

“Төлбөрийн картын тухай журам”-ыг 2011 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр шинэчлэн баталж, 2013 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн 553 дугаар тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан.

1.2. Төлбөрийн систем дэх Төв банк (Монголбанк)-ны оролцоо

Монголбанк нь мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах, мөнгөний бодлого боловсруулж хэрэгжүүлэх, Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүрэг гүйцэтгэх, банкны үйл ажиллагаанд хяналт тавих, банк хоорондын төлбөр тооцоог зохион байгуулах, гадаад валютын улсын нөөцийг эзэмшиж удирдах үндсэн үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн зорилт нь Монгол Улсын Төв банк (Монголбанк)-ны бүрэн эрх, түүний удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлж, төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх, банкны хяналт шалгалттай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.1. Мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах

Монголбанк нь Монгол Улсын мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргах онцгой эрхийг эдэлдэг. Төв банкны тухай хуулиар мөнгөн тэмдэгт хуурамчаар үйлдэх, гүйлгээнд гаргахыг хориглоно. Монгол Улсын мөнгөн тэмдэгтийн албан ёсны нэгж төгрөг нь цаасан дэвсгэрт болон зоосон хэлбэртэй байна. Монгол Улсын мөнгөн тэмдэгтийн хэв, загварыг Монгол Улсын Их Хурал (цаашид УИХ гэх) батална. Монголбанкнаас гүйлгээнд гаргасан төгрөг нь өөрийн нэрлэсэн дүнгээрээ Монгол Улсын нутаг дэвсгэрт хийгдэж буй бүх төлбөр тооцоонд хэрэглэгдэх төлбөрийн хууль ёсны хэрэгсэл юм. Төгрөгийг орлох төлбөрийн бусад хэрэгслийг Монголбанкны зөвшөөрлөөр төлбөр тооцоонд хэрэглэж болно.

Монголбанк нь өөрийн 15 салбар, 2 хэлтсээрээ дамжуулан Монгол Улсад мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргаж, мөн буцаан татан авдаг. Салбар бүр бэлтгэл сантай бөгөөд хөдөө орон нутаг дахь банкуудын салбарыг бэлэн мөнгөөр хангах гол зорилготой. Зөвхөн Төв Монголбанкинд гадаад гүйлгээний үйл ажиллагааг эрхлэн явуулдаг бөгөөд Монголбанкны хэлтэс, салбаруудад тус үйл ажиллагаа хийгдэхгүй.

1.2.2. Мөнгөний бодлого

Монголбанкны зүгээс “Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийн төсөл”-ийг боловсруулж, жил бүрийн 10 дугаар сарын 1-ний өдрийн дотор УИХ-д өргөн барьдаг.

Монголбанкнаас өргөн барьсан үндсэн чиглэлийн төслийг УИХ хэлэлцэж, Төв банкнаас дараагийн жилд баримтлах мөнгө, гадаад валютын нөөц, төлбөрийн системийн бодлого болон банк, санхүүгийн салбарт авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон тогтоол батлан гаргадаг. Монголбанк нь УИХ-д “Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл”-ийн биелэлтийг улирал бүр тайлагнадаг.

1.2.3. Б а н к н ы х я н а л т , ш а л г а л т

Монголбанк нь банкуудын хувьд хуульд заасан үүргийнхээ дагуу бодлого, журам баталж, тэдгээрийн биелэлтэд хяналт тавьж ажиллах эрх бүхий байгууллага юм. Монголбанкнаас баталсан банкны үйл ажиллагаатай холбоотой дараахь журам, зааврыг банкууд мөрдөн ажиллаж байна. Үүнд:

- Банк, түүний нэгж байгуулах зөвшөөрлийн журам,
- Банкинд онцгой дэглэм тогтоох тухай журам,
- Банкны үйл ажиллагаа, санхүүгийн байдалд газар дээр нь иж бүрэн шалгалт хийж үнэлгээ, дүгнэлт өгөх журам,
- Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам,
- Бусад холбогдох журам, заавар.

1.2.4. Т ө л б ө р и й н с и с т е м и й н б о д л о г о , з о х и ц у у л а л т б а х я н а л т

Монгол Улсын төлбөрийн системийн найдвартай, үр ашигтай ажиллагааг бэхжүүлэх үүднээс Төв банк (Монголбанк) нь системийн үйл ажиллагаа болон түүнд оролцогчдод хяналт тавьж ажилладаг. Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 20 дугаар зүйлд “Монголбанк банк хоорондын төлбөр тооцоог зохион байгуулна” гэж заасны дагуу төлбөрийн системийн оролцогчид дараахь бодлого, журмыг мөрдлөг болгон ажиллаж байна.

- Төлбөрийн системийн бодлого
- Төлбөрийн системийн хяналтын бодлого
- Банк хоорондын их дүнтэй гүйлгээний төлбөр тооцооны журам
- Банк хоорондын бага дүнтэй гүйлгээний төлбөр тооцооны журам
- Төлбөрийн картын журам.

1.2.5. Ү й л ч и л г э э н и й н ө х ц ө л

Монголбанк банк хоорондын төлбөр тооцооны найдвартай ажиллагааг хангаж, энгийн хүртээмжтэй байлгах үүднээс дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Үүнд:

- Монголбанк нь оролцогчидтой "Төлбөрийн системийн оролцогч хоорондын их дүнтэй төлбөр тооцоог гүйцэтгэх ажлын гэрээ", “Банк хоорондын бага дүнтэй төлбөр тооцоог гүйцэтгэх ажлын гэрээ” байгуулах,
- Картын нэгдсэн сүлжээний шууд оролцогчидтой Хамтран ажиллах гэрээ байгуулж ажиллах,
- Орон нутагт банк хоорондын бэлэн мөнгөний төлбөр тооцоо гүйцэтгэх салбар нэгж байгуулах,
- Банк хоорондын төлбөр тооцоог зохицуулах заавар, журам боловсруулах.

Монголбанк нь Төв банкны үнэт цаас, Засгийн газрын бонд, банкуудад олгодог өдрийн зээл, овернайт санхүүжилт болон дахин санхүүжилт зэрэг бусад санхүүгийн гүйлгээг дамжуулж, зохион байгуулдаг. Хувь хүн, хуулийн этгээд нь эдгээр үйлчилгээг банкнаас авах боломжтой.

Монголбанк нь төлбөрийн системийн оролцогчоос банк хоорондын төлбөр тооцоог боловсруулсан үйлчилгээний шимтгэлийг “Монголбанкны үйлчилгээний шимтгэлийн ерөнхий нөхцөл”-ийн дагуу авдаг.

1.3. Төл бөрийн систем дэх бусад байгууллагын оролцоо

Монгол Улсад төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлдэг санхүүгийн зуучлагч гол 3 байгууллага нь банкууд, Сангийн яамны Төрийн сангийн газар, Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв юм. Эдгээр санхүүгийн байгууллага нь үзүүлж байгаа үйлчилгээ, зохицуулалтад хамрагдаж буй хэлбэрээрээ хоорондоо ялгаатай.

1.3.1. Банкууд

Банкуудын гол үйл ажиллагаа нь харилцах, хадгаламж төвлөрүүлэх, зээл, төлбөр тооцооны үйлчилгээ, банкны бусад үйлчилгээг иргэд, хуулийн этгээдэд үзүүлэх юм. Монгол Улсад 2012 оны жилийн эцсийн байдлаар 14 банк 182 салбар, 1 078 тооцооны төв, 126 тооцооны касстайгаар үйл ажиллагаа явуулж байна. Дотоодын санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж буй нийт 1 386 банкны нэгж байгаагаас хэдөө орон нутаг дахь банкны нэгж 1 009 байна. Хэдөө, орон нутаг дахь 1 009 нэгжийн 860 нь тооцооны төвийн үйл ажиллагаа явуулж байна.

Гадаад улсаас 1) 2008 онд ING банк, 2) 2010 онд Standard Chartered Bank, 3) 2012 онд Bank of China тус тус Төлөөлөгчийн газраа нээх зөвшөөрөл авсан бөгөөд үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна.

Монголбанкнаас банкуудын үйл ажиллагаанд газар дээрх хяналт шалгалтыг хийж, сар бүр зайнаас хяналт тавьж ажилладаг. Банкуудад жилд хамгийн багадаа 1 удаа газар дээрх шалгалтыг хийдэг байна. Шаардлагатай тохиолдолд Монголбанкны бусад газар, хэлтэс болон Монгол Улсын холбогдох яамд, Засгийн газрын хэрэгжүүлэгч бусад агентлагуудтай хамтран газар дээрх шалгалт хийдэг.

УИХ-ын 2008 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр баталсан Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай хуулиар банкуудад байршиж байгаа иргэдийн хадгаламжид баталгаа гаргасан. Хадгаламж болон харилцахын үлдэгдэлд баталгааг дээрх хууль хэрэгжиж эхэлсэн өдөр буюу 2008 оны 11 дүгээр сарын 25-ны өдрөөс хойш 4 жилийн хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөхөөр тусгасан байна. Энэхүү хуулийн хүчинтэй хугацаа дууссантай холбогдуулан 2013 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль шинээр батлуулсан. Энэ хууль нь банкны мөнгөн хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах зорилго бүхий банкн дахь мөнгөн хадгаламжийн албан журмын даатгалын эрх зүйн үндсийг тогтоож, хадгаламжийн даатгалын сангийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Монгол Улсад банкууд нь төлбөрийн системийн үндсэн буюу шууд оролцогч бөгөөд банкаар дамжин хийгдэж буй харилцагч аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн бэлэн болон бэлэн бус төлбөр тооцоог гүйцэтгэгч байгууллага юм.

Монголбанкнаас баталсан холбогдох журмын дагуу тусгай зөвшөөрөл авсан банк нь Банкны тухай хуулийн 2 дугаар бүлгийн 11 дүгээр зүйлд заасны дагуу төлбөр тооцооны дараахь үйлчилгээг эрхлэн явуулдаг. Үүнд:

1. Банк өөрийн харилцагчид төлбөр тооцооны бүх төрлийн үйлчилгээг түүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр үзүүлэх;
2. Банк харилцагчийн даалгавраар харилцах дансны үлдэгдэлд багтааж мөнгөн хөрөнгийг шилжүүлэх гүйлгээ хийх; (Шүүх болон банкны эрх хүлээн авагчийн шийдвэртэй, эсхүл үл маргалдах журмаар төлөх тухай харилцагчийн гарын үсэг бүхий гэрээ, төлбөрийн баримтыг үндэслэн гүйлгээ хийснийг харилцагчийн даалгавраар гүйлгээ хийсэнд тооцно.)
3. Төлбөр тооцооны үйлчилгээний хүү, шимтгэлийг банк өөрөө тогтоох;
4. Банк нь банк хоорондын төлбөр тооцоог Монголбанкн дахь харилцах дансаараа дамжуулан хийх;
5. Банкны төлбөр тооцооны үйл ажиллагааг хуулиар зохицуулах.

1.3.2. Сангийн яамны Төрийн сангийн газар (Төрийн сангийн газар)

Төрийн сангийн газар (ТСГ) нь Төсвийн хуулийн дагуу төсвийн хэрэгжилтийг хангаж, төлбөр тооцоо гүйцэтгэх, тайлагнах, төсвийн алдагдал, төсөл хөтөлбөрийг хамгийн бага зардлаар төлбөрийн чадвартай уялдуулан санхүүжүүлэх үйл ажиллагааг эрхэлнэ.

ТСГ-ын Төлбөр тооцооны хэлтэс нь улсын төсвийн хэрэгжилтийг хангах үндсэн үүргийнхээ хүрээнд улсын төсвийн орлого, зарлагын гүйлгээг хийх, бүртгэх, түүнд хяналт тавин ажилладаг. Үүнд:

- Төсвийн байгууллагын анхан шатны баримтыг үндэслэн төлбөр тооцоо гүйцэтгэх,
- Цаг хугацаанд нь үнэн зөв бүртгэл хөтөлж, банк хоорондын төлбөр тооцоог гүйцэтгэх

1.3.3. Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв (ҮЦТТТХТ)

ҮЦТТТХТ нь Монголын Хөрөнгийн бирж 1991 онд байгуулагдахад Төлбөр тооцоо, хадгаламжийн алба нэртэйгээр байгуулагдаж, өмч хувьчлалын анхны бүртгэлийг хийж эхэлсэн. Засгийн газрын 2003 оны 72 тоот тогтоолоор Монголын хөрөнгийн биржийн бүтцээс тусгаарлагдан 100 хувь төрийн өмчит, бие даасан хуулийн этгээд болж ҮЦТТТХТ нэртэй болсон. Монгол Улсын хэмжээнд биржийн болон биржүүдийн дунд үнэт цаасны төлбөр тооцоо, СЗХ-оос олгосон тусгай зөвшөөрлийн дагуу үнэт цаасны хадгаламж, өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн явуулж байна.

Тус байгууллага нь үнэт цаастай холбоотой төлбөр тооцооны эрсдэлийг бууруулах үүднээс 2011 онд “Банксүлжээ” системийн оролцогч болж, ҮЦГТ-ийн сүлжээнд холбогдсон. Монголын хөрөнгийн бирж 2012 онд үнэт цаасны төлбөр тооцоог “Т+3” горимд шилжүүлэн ажиллаж байна. МХБ нь 2012 онд нийт 145.1 тэрбум төгрөгийн дүнтэй 133.8 сая ширхэг үнэт цаасны төлбөр тооцоо хийсэн бөгөөд өмнөх оныхтой харьцуулахад арилжааны хэмжээ 32.6 хувиар өссөн байна.

1.3.4. Банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)

ББСБ нь дараахь үйл ажиллагааг явуулах эрхтэй. Үүнд:

- Зээл

- Факторингийн үйлчилгээ
- Төлбөрийн баталгаа гаргах
- Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах
- Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ
- Гадаад валютын арилжаа
- Итгэлцлийн үйлчилгээ
- Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх
- Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө өгөх
- Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын ажиллагаа

Монгол Улсад 2012 оны байдлаар СЗХ-ны зөвшөөрөлтэй нийт 212 ББСБ үйл ажиллагаа эрхэлж байна.

1.3.5. Х а д г а л а м ж, з э э л и й н х о р ш о о (ХЗХ)

ХЗХ нь ББСБ-ын нэгэн адил банкаар дамжуулан манай улсын төлбөрийн системд шууд бус оролцдог. Монгол Улсад 2012 байдлаар нийт 148 ХЗХ үйл ажиллагаагаа эрхэлж байна.

1.3.6. Үндэсний цахим гүйлгээний төв (ҮЦГТ)

Монголбанкны санаачилгаар Монгол Улсын Засгийн газар, Олон улсын хөгжлийн ассоциацийн хооронд байгуулсан “Санхүүгийн чадавхийг хөгжүүлэх төсөл”-ийн дагуу төлбөрийн системийг шинэчлэх ажлын хүрээнд ҮЦГТ (тухайн үеийн Төлбөр тооцооны төв)-ийг байгуулсан.

Дээрх төсөл хэрэгжсэний үр дүнд 2006 оны 2 дугаар сард банк хоорондын бага дүнтэй төлбөр тооцоо, 2009 оны 5 дугаар сард банк хоорондын их дүнтэй төлбөр тооцооны “Банксүлжээ” системийг тус тус нэвтрүүлсэн. Төрөөс 2010 онд баримтлах мөнгөний бодлогын үндсэн чиглэлд тусгагдсан “Картын нэгдсэн сүлжээ”-г нэвтрүүлэх ажлын хүрээнд ҮЦГТ нь төлбөрийн картаар үйлчилдэг банкуудыг холбосон сүлжээг бий болгосон. Уг сүлжээг байгуулснаар “Нэг карт, нэгдсэн сүлжээ” үйлчилгээ нэвтэрч, банк хоорондын төлбөрийн картын үйлчилгээг 24 цагаар тасралтгүй үзүүлэх болсон.

Их, бага дүнтэй төлбөр тооцооны систем болон картын нэгдсэн сүлжээнд баримтлах журмыг төлбөрийн системийн оролцогчид мөрдлөг болгон ажиллаж байна.

1.3.7. М о н г о л ы н б а н к н ы х о л б о о (МБХ)

МБХ нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж буй банк болон банк бус санхүүгийн байгууллагуудыг сайн дурын үндсэн дээр нэгтгэсэн, төрөөс хараат бус, бие даасан, ашгийн бус, гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага юм.

МБХ нь гишүүдийн хууль ёсны, нийтлэг ашиг сонирхол, эрхийг төлөөлөн хамгаалах, банк, санхүүгийн салбарын өмнө тулгарсан бодлогын шинж чанартай асуудалд гишүүдийн үйл ажиллагааг нэгтгэн чиглүүлж, ажилладаг.

2. ТӨЛБӨРИЙН ХЭРЭГСЭЛ

2.1. Б э л э н м ө н г ө

Бэлэн мөнгөөр төлбөр гүйцэтгэх нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хийгдэж буй жижиглэнгийн худалдаа, үйлчилгээний төлбөр тооцооны үндсэн хэлбэр юм. Цалин, тэтгэвэр, тэтгэмжийн дийлэнх нь иргэдэд бэлнээр олгогддог боловч ихэнх байгууллагууд цалинг төлбөрийн картаар олгон хэвшиж байна.

Монгол Улсын мөнгөн тэмдэгтийн албан ёсны нэгж төгрөг нь 1925 оноос хойш ашиглагдаж байна.

Монголбанкнаас 1993 онд гаргасан 1, 5, 10, 20, 50, 100, 500, 1 000, 5 000, 10 000 төгрөгийн, 2006 онд гаргасан 20 000 төгрөгийн мөнгөн дэвсгэртүүд гүйлгээнд ашиглагдаж байна.

2012 оны эцсийн байдлаар 828.4 тэрбум төгрөгийн бэлэн мөнгө гүйлгээнд гарсан байна.

Монголбанкнаас бэлэн бус төлбөрийн хэрэгслийн хэрэглээг нэмэгдүүлж, бэлэн бус төлбөр тооцоо давамгайлсан нийгмийг бүрдүүлэх үндсэн бодлого баримталж, бэлэн мөнгөний хэрэглээг бууруулахыг зорьж байна.

2.2. Б э л э н б у с т ө л б ө р и й н х э р э г с э л

Монголбанк нь олон төрлийн бэлэн бус төлбөрийн үйлчилгээг үзүүлдэг ба одоогийн байдлаар кредит шилжүүлгийн гүйлгээ зонхилж байна.

2.2.1. Бэлэн бус төлбөрийн хэрэгсэл

2.2.1.1. Кредит шилжүүлэг

Монголбанкаар 2012 оны эцсийн байдлаар нийт 43.2 их наяд төгрөгийн 7.1 сая ширхэг банк хоорондын гүйлгээ дамжсан байна.

Харилцагч төлбөрийн даалгаврын цахим эсхүл цаасан хэлбэрийг ашиглан төлбөр хийх боломжтой. Банк хоорондын төлбөр тооцооны системд төлбөрийн даалгаврын цахим хэлбэрийг ашигладаг бөгөөд банкууд нь төлбөрийн даалгавар дахь гүйлгээг үүсгэж, гүйлгээний мэдээллийн бүтцээр кодчлон дамжуулж, мөн хүлээн авч, гүйлгээ нэг бүрийн мэдээллийг компьютерийн системд хадгалдаг.

2.2.1.2. Дебит шилжүүлэг

Монгол Улсын төлбөрийн системд банк хооронд дебит шилжүүлэг харьцангуй бага хэмжээгээр хийгддэг. Энэ нь банк дотроо буюу тухайн харилцагч болон төлбөр хүлээн авагч байгууллагын данс нэг банкинд байршиж байх тохиолдолд гүйцэтгэгддэг бөгөөд харилцагчтай байгуулсан гэрээг үндэслэн орон сууцны төлбөр, суурин утас, гар утас, интернэтийн төлбөр зэргийг дебит шилжүүлгээр хийдэг.

2.2.1.3. Чек

Монголын банкууд олон улсын банк, санхүүгийн байгууллагаас гаргасан чекийг худалдах, худалдан авах, бэлэн мөнгө болгох зэрэг үйлчилгээ эрхэлж болно. Энэ төрлийн үйлчилгээг ихэнх тохиолдолд гадны иргэд авдаг байна.

2.2.1.4. Төлбөрийн картын төлбөр тооцоо

Манай улсын томоохон банкуудын нэг болох Голомт банк нь 1999 оны 2 дугаар улиралд “Master card international” компанийн гишүүн болж Мастер картыг гаргаснаар олон улсын төлбөрийн картын сүлжээнд холбогдсон. Ингэснээр бэлэн бус төлбөр тооцооны хэрэгсэл болох төлбөрийн картын үйлчилгээ Монголд анх нэвтэрсэн юм. Одоогийн байдлаар 9 банк энэхүү үйлчилгээг үзүүлж байна. Эдгээрээс ХААН банк, Худалдаа хөгжлийн банк, Голомт банк, Хадгаламж банк гэсэн 4 банк өөрийн гэсэн төлбөрийн картын сүлжээтэй ба үлдсэн банкууд нь дээрх 4 банкны банкуудын дэд гишүүн байдлаар төлбөрийн картаар хийгдэж буй карт эзэмшигчдийнхээ төлбөр тооцоог гүйцэтгэж байна. Банк хоорондын төлбөрийн картын гүйлгээ нь ҮЦГТ-ийн сүлжээгээр дамжин хийгдэж байна.

Карт эзэмшигчдийн тоо жилээс жилд өсч 2012 оны эцсийн байдлаар давхардсан тоогоор 2.9 саяд хүрснээс 1.1 сая нь картаа идэвхтэй ашиглаж байна. Мөн үеийн байдлаар төлбөрийн картаар 5.3 их наяд тэрбум төгрөгийн 69.4 сая ширхэг гүйлгээ хийгдсэн байна². Монгол Улсад чип болон соронзон тууз бүхий төлбөрийн картууд төлбөр тооцоонд ашиглагдаж байна.

Монголбанк нь үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийг бэлэгдэн нэрлэсэн үндэсний брэнд “₮ карт” (₮ карт)-ыг банкуудтай хамтран гаргах ажлыг амжилттай зохион байгуулж, 2012 онд нийтийн хүртээл болгосон.

Тус картыг гаргаснаар иргэдэд бэлэн мөнгөөр үйлчилгээ үзүүлдэг төрийн байгууллагууд болох Иргэний Бүртгэлийн газар, Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн газар, Гаалийн Ерөнхий газар, Татварын Ерөнхий газар зэрэг шимтгэл, татвар, хураамж төвлөрүүлдэг үйлчилгээний төлбөр тооцоог “₮ карт”-аар гүйцэтгэх боломж нээгдэж байгаа юм. Түүнчлэн, иргэдийн цалин, тэтгэвэр, халамжийн мөнгө, хүүхэд бүрт олгож буй тэтгэмж зэрэг төрөөс иргэдэд олгож буй тэтгэмжийг энэхүү төлбөрийн картаар, бэлэн бус хэлбэрээр олгох нь төрийн үйлчилгээ иргэдэд шуурхай хүрч эхлэх юм.

Монголбанкнаас “₮ карт” гаргах, хүлээн авах тусгай зөвшөөрлийг картын үйл ажиллагаа эрхлэгч 9 банк авсан. “Төлбөрийн картын хэрэглээний судалгаа”-гаар 2012 оны байдлаар “₮ карт”-ийг 91.3 мянган эзэмшигчтэй болсон байна.

Голомт банк, Худалдаа хөгжлийн банк, ХААН банк дотооддоо болон олон улсад ашиглагдах дебит, кредит карт (Виза интернэшнл, Мастер карт, Юнион пэй интернэшнл)-ыг тус тус гаргасан. Харин банкууд Виза интернэшнл, Мастер карт, Юнион пэй интернэшнл, Американ экспрес, JCB картыг хүлээн авч байна.

2.2.1.5. Урьдчилсан төлбөрт карт (цахим мөнгө)

Карт эзэмшигч нь тусгай зориулалтаар мөнгөн хөрөнгийг урьдчилан тусгаарласан дансанд байршуулан шууд хандах боломжтой төлбөрийн картыг урьдчилсан төлбөрт карт гэнэ. Монгол Улсад урьдчилсан төлбөрт картыг голчлон үйлчилгээний байгууллагуудад бэлгийн карт (gift card) хэлбэрээр ашиглаж байна.

2.2.1.6. Мобайл банкны үйлчилгээ

Банкны үйлчилгээ авах боломжгүй алслагдсан хөдөө орон нутгийн иргэдэд банкны үйлчилгээг хүргэх зорилгоор банкууд уг шинэлэг үйлчилгээг нэвтрүүлж байна. Харилцагч

² Эх үүсвэр: ТБЗА-ны системийн зохицуулагчийн хийсэн “Төлбөрийн картын хэрэглээний судалгаа” хуудас №8, Хүснэгт №6

банкинд байгаа өөрийн нэрийн данс руу ямар нэгэн хөдөлгөөнт төхөөрөмж (тухайлбал: гар утас, интернэт гэх мэт)-өө ашиглан алсаас хандаж гүйлгээ хийх үйлчилгээ юм. Мобайл банкны үйлчилгээг 2012 оны эцсийн байдлаар 710 мянган хэрэглэгч төлбөр тооцоонд ашиглаж байна.

Монголбанкны Ерөнхийлөгч, СЗХ болон Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга нарын 2012 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А-187/244/261 тоот хамтарсан тушаалаар “Хөдөлгөөнт банкны үйлчилгээ, цахим мөнгөний талаар баримтлах бодлого”-ыг баталсан. Энэхүү бодлого нь бэлэн бус төлбөрийн хэрэгслийг дэмжих, технологийн дэвшлийг ашиглаж төлбөрийн системийн дэд бүтцийг хөгжүүлэх, улмаар санхүүгийн болон санхүүгийн бус үйлчилгээг хүн амын орлогын түвшин, газар зүйн байршил, цаг хугацаанаас үл хамааран найдвартай, түргэн шуурхай хүргэх боломжийг бүрдүүлэх зорилготой юм.

Мессэж банкны үйлчилгээ нь өөрийн данс байршиж байгаа банк руу гар утсаа ашиглан мессэж илгээн, төлбөр тооцоогоо гүйцэтгүүлэх үйлчилгээ юм. Сүүлийн жилүүдэд манай улсад мессэж банкны үйлчилгээ өргөжиж нийт 9 банк, 1 банк бус санхүүгийн байгууллага тус үйлчилгээг харилцагчиддаа үзүүлж байна. Тухайлбал, Хас банкны “AMAR” үйлчилгээ нь аль ч үүрэн холбооны операторын хэрэглэгч худалдан авсан бараа, үйлчилгээнийхээ төлбөрийг гар утсаа ашиглан төлөхөөс гадна дансандаа мөнгө хийх, данснаасаа бэлэн мөнгө авахдаа банкны салбарт очилгүйгээр, банкны салбар хаасан хойно ч тус үйлчилгээ үзүүлэгч агентаар дамжуулан гүйлгээгээ хийх боломжтой юм.

2.2.2. Бэлэн бус төлбөр тооцооны төхөөрөмж

2.2.2.1. АТМ төхөөрөмж

Монгол Улсад анх 2001 онд АТМ төхөөрөмж ашиглан бэлэн мөнгө авах үйлчилгээ нэвтэрсэн. Төлбөрийн картын зах зээл өргөжихийн хирээр АТМ төхөөрөмжийн тоо өсч 2012 оны байдлаар 915 болсон байна. АТМ төхөөрөмжөөр 2012 оны байдлаар нийт 4 их наяд төгрөгийн 57.4 сая ширхэг гүйлгээ хийгдсэн байна.

2.2.2.2. ПОС, ПОБ терминал

ПОС терминал 2012 оны жилийн эцсийн байдлаар 7 210 ширхэг, ПОБ терминал 2 384 ширхэг байна. Мөн хугацаанд ПОС терминалаар 735.1 тэрбум төгрөгийн 10.3 сая ширхэг гүйлгээ, ПОБ терминалаар 577 тэрбум төгрөгийн 1.7 сая ширхэг гүйлгээ тус тус хийгдсэн байна.

2.2.2.3. Интернэт банк

Энэ үйлчилгээ нь интернэтээр дамжуулан банкинд байгаа өөрийн нэрийн дансаар олон улс, банк хооронд, өөрийн данс хооронд мөнгө шилжүүлэх, төлбөр төлөх, үлдэгдэл шалгах зэргээр санхүүгийн болон санхүүгийн бус гүйлгээг хийж боломжийг харилцагчид олгодог давуу талтай.

Интернэт банкны үйлчилгээг 2002 оноос банкууд нэвтрүүлж, одоогийн байдлаар 9 банк энэхүү үйлчилгээг үзүүлж байна. 2012 оны байдлаар интернэт банкны хэрэглэгчдийн тоо 236.1 мянгад хүрч, 33.8 тэрбум төгрөгийн 257.5 мянган ширхэг гүйлгээ хийжээ.

2.2.3. Бусад

ТТҮЗ-ийн 2009 онд баталсан 2009-2014 онуудад Монгол Улсын төлбөрийн системийг хөгжүүлэх дунд хугацааны стратегийн баримт бичигт тусгаснаар “Бэлэн бус төлбөрийн

хэрэгслийн хэрэглээг нэмэгдүүлэх, шинэ систем нэвтрүүлэх” ажлын хүрээнд санхүүгийн үйлчилгээг иргэдэд газар зүйн байрлал, орлого, цаг хугацаанаас үл хамаарч хүртээмжтэйгээр хүргэх боломжтой болж байна.

Бэлэн валют банкинд тушааж гадаад руу гуйвуулах үйлчилгээ манай улсад өргөнөөр ашиглагдаж байна. Одоогийн байдлаар 2000 онд анх үйлчилгээгээ нэвтрүүлсэн “Western Union”-ийн сүлжээнд 4 банк, 2001 онд үйлчилгээний нэвтрүүлсэн “Moneygram”-ын сүлжээнд 6 банк тус тус нэгдсэн байна. Мөн манай улсад энгийн болон шилжих вексель ашиглагдаж байна.

3. ТӨЛБӨРИЙН СИСТЕМ

3.1. Ерөнхий танилцуулга

Монгол Улс банкны 2 шатлалт систем рүү шилжсэн 1991 оноос Монголбанк нь банк хоорондын төлбөр тооцоог холимог дүнтэйгээр дамжуулж байсан. Харин 2006 оноос эхлэн банк хоорондын төлбөр тооцоог дүнгээр нь их, бага дүнтэй гүйлгээ гэж ангилан, их дүнтэй гүйлгээг “Банксүлжээ” системээр, бага дүнтэй гүйлгээг ҮЦГТ-өөр тус тус дамжуулж, өдрийн эцэст үр дүнгийн тооцооллыг “Банксүлжээ” систем дээр хааж, нийт оролцогчдын Монголбанкин дахь харилцах дансад харилцан суутгах зарчмаар тусгаж байна.

Зураг1. Монгол Улсын төлбөрийн системийн бүдүүвч



3.2. Их дүнтэй төлбөр тооцооны “Банксүлжээ” систем

Банк хоорондын их дүнтэй төлбөр тооцооны “Банксүлжээ” систем нь оролцогчдын илгээсэн гүйлгээ бүрийг бодит цагийн горимоор дамжуулж, үр дүнгийн тооцооллыг тухайн мөчид хийснээрээ банкуудад төлбөр тооцооны эрсдэлийг хянах, активын зохистой удирдлага явуулах боломжийг олгодог, түүнчлэн бусад төлбөр тооцооны систем (үнэт цаас, валютын арилжаа, бага дүнтэй төлбөр тооцоо гэх мэт)-ийг холбодог систем юм. Энэхүү системийн гол давуу тал нь гүйлгээ нэг бүрийг бодит цагийн горимоор нэг банкнаас нөгөө банк руу дамжуулж, төлбөр тооцоог гүйцэтгэдэгт оршино. “Банксүлжээ” системийг нэвтрүүлснээр Монгол Улсын төлбөрийн системийн тогтолцоо олон улсын жишигт хүрсэн юм.

Хүснэгт 1. “Банксүлжээ” системээр дамжсан гүйлгээний тоо, дүн (2012 оны байдлаар) (мянган ширхэг, их наяд төгрөг)

Утга	2012 он	
	Тоо	Дүн
Их дүнтэй гүйлгээ	891.6	42.7

Нэгж гүйлгээний дундаж дүн, сая төгрөгөөр		47.9
Нэг өдрийн дундаж гүйлгээ	3.64	0.17
<i>Нийт гүйлгээнд эзлэх хувь</i>	<i>12.5 %</i>	<i>98.8 %</i>

3.2.1. Үйл ажиллагааны заавар, журам

“Банксүлжээ” системийн үйл ажиллагааг хэвийн, тасралтгүй хангах үүднээс “Төлбөрийн системийн оролцогч хоорондын их дүнтэй төлбөр тооцооны журам”-ыг мөрдөж, системийн оролцогчидтой “Төлбөрийн системийн оролцогч хоорондын их дүнтэй төлбөр тооцоог гүйцэтгэх ажлын гэрээ” байгуулан хамтран ажилладаг.

3.2.2. Системийн оролцогч

”Банксүлжээ” системд одоогоор Монголбанк, 15 банкны төв, Сангийн яамны Төрийн сангийн газар болон ҮЦТТТХТ оролцогчоор бүртгэгдсэн байна. Системийн оролцогчийн эрх олгоход тавигдах үндсэн шаардлага болон эрхийг гүдгэлзүүлэх, цуцлах ерөнхий нөхцөлүүдийг Монголбанкны “Төлбөрийн системийн оролцогч хоорондын их дүнтэй төлбөр тооцооны журам”-д тодорхойлж, нийтэд ил тод болгосон.

3.2.3. Гүйлгээний төрөл

“Банксүлжээ” системээр дараахь гүйлгээг дамжуулна:

- оролцогч хоорондын их дүнтэй төгрөгийн гүйлгээ;
- оролцогчийн төлбөрийн чадварыг хангуулахтай холбоотой хийгдэх банк хоорондын зээл, хадгаламж, репо арилжаа, овернайт репо санхүүжилтийн гүйлгээ;
- овернайт хадгаламжийн гүйлгээ;
- бэлэн мөнгөний чек, үнэт цаас, аккредитивтай холбоотой гүйлгээ;

“Банксүлжээ” систем нь гүйлгээ дамжуулахдаа MT103 болон MT202 мессэж форматыг ашигладаг.

3.2.4. “Банксүлжээ” системийн үйл ажиллагаа

а/ дараахь үйл ажиллагаатай холбоотой цахим төлбөрийг боловсруулах:

- Монголбанкны мөнгөний бодлого хэрэгжүүлэх үйл ажиллагаа (зээл, хадгаламж, гадаад валютын арилжааны төлбөр тооцоо болон бусад гүйлгээ)
- Монголбанк, Засгийн газар болон системийн оролцогчдын хоорондын их дүнтэй төлбөр
- Банкуудын заавал байлгах нөөцтэй холбоотой төлбөр.

б/ дараахь мэдээллээр хангах зорилгоор цахим мэдээлэл боловсруулах:

- Оролцогчийн харилцах дансны үлдэгдэл,
- Банк хоорондын бага дүнтэй гүйлгээний үр дүнгийн тооцоолол.

“Банксүлжээ” систем нь тогтмол цагийн хуваариар буюу улс нийтээр амрах амралт, баяр ёслолын өдрүүдийг оруулахгүйгээр Даваа гарагаас Баасан гарагт 9:00 цагаас 18:00 цагийн хооронд ажиллана.

3.2.5. “Б а н к с ү л ж э э” с и с т е м э э р т ө л б ө р т о о ц о о г ү й ц э т г э х

Төлбөр гүйцэтгэгч банкны Монголбанкин дахь харилцах дансны үлдэгдэл төлбөр тооцоо гүйцэтгэхэд хүрэлцээтэй байгаа тохиолдолд тухайн гүйлгээний үр дүнгийн тооцоолол төлбөр хүлээн авагч банкны дансанд бодит цагийн горимоор тусгагдана. Хэрэв харилцах дансны үлдэгдэл хүрэлцэхгүй бол үр дүнгийн тооцоолол хийгдэхгүй бөгөөд гүйлгээний дараалал үүснэ. Банкууд нь гүйлгээгээ илгээх эрэмбийг тогтоож, дарааллыг зохицуулах боломжтой. Дараалалд хүлээгдэж буй гүйлгээнүүдийг эрэмбийнх нь дагуу дамжуулах бөгөөд адил эрэмбэтэй гүйлгээнүүдийн хувьд эхэлж ирснийг эхэлж гүйцэтгэх /FIFO/ зарчмыг баримтална. Монголбанкин дахь харилцах дансны үлдэгдлээс заавал байлгах нөөцийг тооцоход нөөц дутагдсан тохиолдолд Монголбанк нь банкинд дутуу дүнг нөхөх шаардлага тавьж Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, Банкны тухай хуульд заасан арга хэмжээг авах эрхтэй.

3.2.6. Э р с д э л и й н у д и р д л а г а

Төлбөр тооцооны эрсдэлээс урьдчилан сэргийлэх, удирдах зорилгоор Монголбанк нь дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлдэг. Үүнд:

Зээлийн эрсдэл

“Банксүлжээ” систем нь бодит цагийн горимоор төлбөр тооцоог гүйцэтгэдэг тул төлбөрийн системийн оролцогч өөрийн харилцах дансны үлдэгдэлээ тухай бүртээ хянах боломжтой. Иймээс оролцогчидод банк хоорондын төлбөр тооцоотой холбоотой зээлийн эрсдэл үүсдэггүй.

Төлбөрийн чадварын эрсдэл

Системийн оролцогчийн Монголбанкин дахь харилцах дансны үлдэгдэл нь төлбөр тооцоо гүйцэтгэхэд хүрэлцэхгүй байгаа тохиолдолд харилцах дансанд эх үүсвэр байрших хүртэл “Банксүлжээ” систем тухайн оролцогчийн илгээсэн гүйлгээг дараалалд оруулна. Ийм нөхцөл байдал үүссэн үед банк нь Монголбанкнаас холбогдох журмын дагуу овернайт болон өдрийн зээл авч харилцах дансаа зузаатгах боломжтой.

Үйл ажиллагааны эрсдэл

“Банксүлжээ” систем нь аюулгүй, найдвартай байхаар зохион байгуулагдсан. Монголбанкнаас үйл ажиллагааны эрсдэлийг багасгах зорилгоор Онцгой байдлын төлөвлөгөө баталсан. Уг төлөвлөгөөний дагуу “Банксүлжээ” систем тасалдах тохиолдолд зайн нөөц төвийг ашиглаж, системийн тасралтгүй ажиллагааг хангана.

3.2.7. Т ө л б ө р т о о ц о о н ы ш и м т г э л

Монголбанк нь системийн оролцогчидод харилцах данс нээхдээ шимтгэл авдаггүй бөгөөд харин “Банксүлжээ” системээр төлбөр тооцоо дамжуулан гүйцэтгэхэд “Монголбанкны үйлчилгээний шимтгэлийн ерөнхий нөхцөл”-ийн 1.1-д заасны дагуу дебит гүйлгээ бүрт 300 төгрөгийн шимтгэл тооцдог.

3.3. Бага дүнтэй төлбөр тооцооны систем

Монголбанкны ҮЦГТ нь Монголбанк, 15 банкны төв, Сангийн яамны Төрийн сангийн газар, ҮЦГТТХТ-тэй үндсэн шугам болох шилэн кабель, нөөц шугам болох физик кабелиар тус тус холбогдсон “Санхүүгийн дундын нэгдсэн сүлжээ”-гээр банк хоорондын бага дүнтэй гүйлгээний төлбөр тооцоог зохион байгуулах, удирдах програм, техник хангамжийн цогц бүтэц болон түүний нөөц төвүүдийг хариуцан ажилладаг.

ҮЦГТ нь банк хоорондын бага дүнтэй төлбөр тооцоог тасралтгүй, найдвартай дамжуулах үндсэн болон нөөц төвүүдтэй бөгөөд тэдгээрийн толгой компьютерууд нь зайлшгүй тохиолдолд мэдээллээ харилцан шилжүүлж ажиллах техник, технологиор бүрэн хангагдсан.

Хүснэгт 2. Банк хоорондын бага дүнтэй гүйлгээний тоо, дүн
(мянган ширхэг, их наяд төгрөг)

Утга	2012 он	
	Тоо	Дүн
Бага дүнтэй гүйлгээ	6246.2	0.5
Нэгж гүйлгээний дундаж дүн, мянган төгрөг		80.0
Нэг өдрийн дундаж гүйлгээ	24.8	0.01
<i>Нийт гүйлгээнд эзлэх хувь</i>	87.5 %	1.2 %

3.3.1. Үйл ажиллагааны заавар, журам

ҮЦГТ нь үйл ажиллагаандаа “Банк хоорондын бага дүнтэй төлбөр тооцооны журам”-ыг мөрдөн, системийн оролцогчидтой “Банк хоорондын бага дүнтэй гүйлгээний төлбөр тооцоог гүйцэтгэх ажлын гэрээ” байгуулан ажилладаг.

3.3.2. Системд оролцогч

Банк хоорондын бага дүнтэй төлбөр тооцоонд оролцогчид нь Монголбанк, 15 банкны төв, Сангийн яамны Төрийн сангийн газар, ҮЦГТТХТ болно.

Банк хоорондын бага дүнтэй гүйлгээ нь “Санхүүгийн дундын сүлжээ”-гээр дамжин явагддаг бөгөөд олон улсын санхүүгийн мэдээний стандарт болох ISO8583 болон Монголбанкнаас тавьсан бусад шаардлагыг хангасан байдаг.

3.3.3. Төлбөр тооцоо

“Санхүүгийн дундын сүлжээ”-гээр дамжуулан дараахь үйлчилгээг банк, санхүүгийн байгууллагуудад үзүүлдэг:

- Оролцогчдоос банк хоорондын бага дүнтэй гүйлгээний төлбөр тооцоонд орох гүйлгээний цахим мэдээллийг “Санхүүгийн дундын сүлжээ”-ээр ажлын өдрийн 9:10 цагаас 17:00 цагийн хооронд хүлээн авч дамжуулна,
- Банк хоорондын бага дүнтэй гүйлгээний үр дүнгийн тооцоолол боловсруулж, “Банксүлжээ” системд өдрийн эцэст дамжуулна.

3.3.4. Үйл ажиллагаа

ҮЦГТ-ийн үндсэн болон нөөц төв нь банк хоорондын төлбөр тооцоог тасралтгүй, найдвартай дамжуулан ажиллаж байна. Онцгой байдлын үед ҮЦГТ-ийн үндсэн төвийн толгой компьютерээс нөөц төвийн толгой компьютер луу мэдээллийг шилжүүлэн ажиллах боломжтой юм.

“Санхүүгийн дундын сүлжээ”-гээр дамжуулан дараахь үйлчилгээг банк, санхүүгийн байгууллагуудад үзүүлдэг:

1. Банк хоорондын бага дүнтэй гүйлгээ, үр дүнгийн тооцооны дамжуулалт,
2. Банксүлжээ системийн сүлжээний холболтууд,
3. Төв банкны үнэт цаасны онлайн системийн мэдээллийн дамжуулалт,
4. Зээлийн мэдээллийн сангийн мэдээллийн дамжуулалт, (банкны төвөөс Монголбанк хүртэл)

3.3.5. Эрсдэлийн удирдлага

Монголбанкнаас төлбөр тооцоотой холбоотой гарч болзошгүй эрсдэлээс сэргийлэх олон арга хэмжээ хэрэгжүүлж байна.

Зээлийн эрсдэл

Бага дүнтэй төлбөр тооцооны систем нь дебит, кредит гүйлгээ болон картын гүйлгээ гэх мэт олон тооны бага дүнтэй гүйлгээ боловсруулах хүчин чадалтай систем юм. Зээлийн эрсдэлийг буруулах зорилгоор Монголбанк бага дүнтэй гүйлгээний мөнгөн дүнгийн дээд хязгаарыг тогтоодог.

Төлбөрийн чадварын эрсдэл

Банкны заавал байлгах нөөц нь төлбөрийн чадварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх гол хэрэгсэл болдог.

Үйл ажиллагааны эрсдэл

Тус эрсдэлийг хязгаарлах хэд хэдэн арга зам бий:

- “Санхүүгийн дундын сүлжээ”-нд гэнэтийн саатал болон компьютер, програм, техник хангамжийн алдаа гарсан тохиолдолд нөөц сервер, програм хангамжийг ашиглан банк хоорондын төлбөр тооцоог хийх,
- Онцгой байдлын төлөвлөгөөг мөрдөж ажиллах,
- Шаардлагатай тохиолдолд нөөц төв рүү шилжих.

3.3.6. Төлбөр тооцооны шимтгэл

Тус сүлжээгээр банк хоорондын бага дүнтэй гүйлгээ дамжуулахад “Монголбанкны үйлчилгээний шимтгэлийн ерөнхий нөхцөл”-ийн 1.2-д заасны дагуу дебит гүйлгээ тус бүрээс 200 төгрөгийн шимтгэл авдаг.

Банк хоорондын бага дүнтэй гүйлгээ нь 2012 оны эцсийн байдлаар нийт банк хоорондын гүйлгээний дүнгийн 1.2 хувь, гүйлгээний тооны 87.5 хувийг тус тус эзэлж байна.

3.4. Төлбөрийн картын систем

Монгол Улсын хэмжээнд бэлэн бус төлбөр тооцоо давамгайлсан нийгмийг бий болгох, ялангуяа төлбөрийн картын үйлчилгээг хөгжүүлэхэд чухал ач холбогдол бүхий “Картын нэгдсэн сүлжээ”-нд 2010 оны 6 дугаар сарын 16-ны өдөр сүлжээний үндсэн гишүүд болох ХААН банк, Худалдаа хөгжлийн банк, Голомт банк, дэд гишүүд болох Капитал банк, Улаанбаатар хотын банк нэгдэж, албан ёсоор нээлтээ хийсэн. Уг сүлжээнд 2012 оны байдлаар төлбөрийн картын үйл ажиллагаа эрхэлж буй бүх банк нэгдсэн.

3.4.1. Үйл ажиллагааны заавар, журам

“Картын нэгдсэн сүлжээ”-нд оролцогчдын гол мөрдөж ажиллах журам нь “Төлбөрийн картын журам” бөгөөд ҮЦГТ нь гишүүн банкуудтай “Хамтран ажиллах гэрээ” байгуулан ажилладаг.

3.4.2. Системд оролцогч

“Картын нэгдсэн сүлжээ”-ний оролцогчид нь Монголбанк, 10 банк байна. Банк хоорондын төлбөрийн картын гүйлгээ нь “Санхүүгийн дундын сүлжээ”-ээр дамжин олон улсын санхүүгийн мэдээний ISO8583 стандарт болон Монголбанкнаас баталсан журам, зааврын шаардлагыг хангасан байх ёстой.

3.4.3. Үйл ажиллагаа

“Картын нэгдсэн сүлжээ”-ны үндсэн гишүүнтэй байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ний дагуу уг сүлжээгээр хийгдэх төлбөр тооцоо нь дараахь 4 зарчим (initiation, authentication, authorization, clearing and settlement)-ыг хангаж, олон улсын “ISO8583” стандартын дагуу “Санхүүгийн дундын сүлжээ”-гээр 24 цагийн турш (24/7) бодит цагийн горимоор хийгддэг.

3.4.4. Үр дүнгийн тооцоолол

“Картын нэгдсэн сүлжээ”-ны үндсэн гишүүдтэй байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ний дагуу уг сүлжээгээр хийгдэх төлбөр тооцоо нь дараахь зарчмаар явагдаж байна. Үүнд:

- Төлбөрийн картын гүйлгээг “Санхүүгийн дундын сүлжээ”-гээр 24 цагийн турш (24/7) бодит цагийн горимд зөвхөн төгрөгөөр илэрхийлж дамжуулж, боловсруулна,
- Карт гаргагч болон карт хүлээн авагч банкны өдрийн эцсийн үр дүнгийн тооцоолол нь Монголбанкин дахь тухайн банкны харилцах дансаар харилцан суутгах зарчмаар, төгрөгөөр гүйцэтгэгдэнэ.

Зураг 2. Картын нэгдсэн сүлжээний бүдүүвч



3.4.5. Эрсдэлийн удирдлага

"Картын нэгдсэн сүлжээ"-ний тасралтгүй, найдвартай үйл ажиллагааг хангах, гарсан аливаа саатал, гэмтлийг шийдвэрлэхийн тулд "Банк хоорондын төлбөрийн картын гүйлгээтэй холбоотой гомдол, маргаан шийдвэрлэх заавар"-ыг мөрдлөг болгож ажиллана.

3.4.6. "Картын нэгдсэн сүлжээ" - ний шимтгэл

"Картын нэгдсэн сүлжээ"-ны үндсэн гишүүн банкуудтай байгуулсан "Хамтран ажиллах гэрээ"-ний дагуу гүйлгээний шимтгэлийг дараахь байдлаар тогтоосон. Үүнд:

Карт хүлээн авагч банк нь карт эзэмшигчээс:

1. АТМ төхөөрөмж дээр хийгдсэн банк хоорондын төлбөрийн картын бэлэн мөнгө авах гүйлгээнээс 500 (таван зуун) төгрөг;
2. ПОБ терминал дээр хийгдсэн бэлэн мөнгө авах 800 000 (найман зуун мянган) төгрөг хүртэлх гүйлгээнээс 500 (таван зуун) төгрөг;
3. АТМ төхөөрөмж, ПОБ терминал дээр хийсэн үлдэгдэл шалгах гүйлгээний шимтгэл 100 (нэг зуун) төгрөг тус тус авдаг.

ҮЦГТ нь “Картын нэгдсэн сүлжээ”-ний үйл ажиллагааг дэмжих зорилгоор 2011 оны 11 дүгээр сар хүртэл хугацаанд карт гаргагч, хүлээн авагч банкуудаас банк хоорондын төлбөрийн картын гүйлгээний шимтгэл авахгүй байхаар гэрээнд тусгасан. Харин 2013 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн банкуудаас дараахь шимтгэлийг авч эхэлсэн байна. Үүнд:

1. АТМ төхөөрөмж, ПОБ терминал дээр хийгдсэн үлдэгдэл шалгах гүйлгээ тус бүрээс тогтмол 10 (арван) төгрөгийг карт гаргагч банкнаас,
2. АТМ төхөөрөмж, ПОБ терминал дээр хийгдсэн бэлэн мөнгө авах гүйлгээ тус бүрээс тогтмол 40 (дөчин) төгрөгийн шимтгэлийг карт хүлээн авагч банкнаас,
3. ПОС терминал дээр хийгдсэн 3 000 (гурван мянган) төгрөгөөс дээш дүнтэй гүйлгээ тус бүрээс тогтмол 20 (хорин) төгрөгийг карт хүлээн авагч банкнаас,
4. ПОС терминал дээр хийгдсэн 3 000 (гурван мянган) төгрөг хүртэлх дүнтэй гүйлгээ тус бүрээс тогтмол 1 (нэг) төгрөгийн шимтгэлийг авах бөгөөд карт гаргагч, хүлээн авагч банкуудаас хувааж авах.

3.5 Гадаад валютын хил дамнасан гуйвуулгын систем

Гадаад валютын хил дамнасан гуйвуулга нь дотоод болон гадаадын эрх бүхий банкуудын харилцах дансаар дамжин хийгддэг. Монгол Улсад гадаад төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 13 банк авсан байна. Тэдгээр банкууд нь гадаад төлбөр тооцоондоо аккредитив, гуйвуулга, баталгаа, төлбөрийн нэхэмжлэл гэсэн хэрэгслүүдийг ашиглаж байна. Гадаад валютын хил дамнасан гуйвуулга нь Монголбанк ба бусад орны төв банк хоорондын үр дүнгийн тооцооллын гэрээ, Монголбанкны журам, эрх бүхий банк ба харилцагч банкуудын хооронд байгуулсан гэрээгээр зохицуулагдана.

Гадаад валютын хил дамнасан гуйвуулгыг данс эзэмшигчийн төлбөрийн даалгаврын дагуу харилцах данснаас хасалт хийж гүйцэтгэнэ.

Банкууд төлбөрийн даалгаврыг СВИФТ сүлжээгээр дамжуулна. Манай улс 1997 онд СВИФТ сүлжээнд нэгдсэн бөгөөд банкууд энэхүү сүлжээгээр гадаад төлбөр тооцоог гүйцэтгэж байна. Монголбанк нь 2012 онд СВИФТ-ийн сүлжээгээр нийт 10 159 төлбөрийн мессэж хүлээн авч, 2 789 мессэж илгээсэн байна.

4. ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨР ТООЦОО, ҮР ДҮНГИЙН ТООЦООЛОЛ

4.1. Ерөнхий зүйл

Монгол Улсад үнэт цаасны арилжааны дараахь үйлчилгээ буюу үнэт цаасны төлбөр тооцоо, үр дүнгийн тооцооллыг гүйцэтгэх эрх бүхий цорын ганц байгууллага нь төрийн өмчит хувьцаат компани болох “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” (ҮЦТТТХТ) юм. ҮЦТТТХТ нь үнэт цаасыг биет бус хэлбэрээр хадгалдаг төвлөрсөн хадгаламжийн систем бөгөөд үнэт цаасны шилжүүлгийг дансны бүртгэлийн дагуу хийдэг.

Үнэт цаасны шилжүүлгийн төрлөөс хамааран мөнгөн хөрөнгийн шилжүүлгийг арилжааны банкинд байршиж буй дансаар дамжуулан гүйцэтгэдэг.

4.2. Х а м р а х х ү р э э

Монголын хөрөнгийн биржид 2012 оны байдлаар бүртгэлтэй нийт 329 хувьцаат компани байгаагаас 23 буюу 6.9 хувь нь 100 хувь төрийн өмчит, 29 буюу 8.8 хувь нь төрийн өмчийн оролцоотой, 277 буюу 84.2 хувь нь бүрэн хувьчлагдсан, олон нийтэд нээлттэй компани байна.

4.2.1. Э р с д э л и й н у д и р д л а г а

ҮЦТТТХТ нь үр дүнгийн тооцооллыг Т+3 зарчмаар гүйцэтгэдэг. Энэхүү зарчим нь арилжаа хийгдснээс хойш гурван өдрийн дараа харилцагч үнэт цаасны төлбөр тооцооны банкин дахь дансандаа үнэт цаас худалдан авах төлбөрөө 100 хувь урьдчилан байршуулдаг. Энэ нь арилжаа хийгдсэнтэй холбоотой төлбөр тооцооны эрсдэл үүсэхээс бүрэн хамгаалж байна.

ҮЦТТТХТ нь төлбөр тооцоо, үр дүнгийн тооцооллыг гүйцэтгэхдээ болзошгүй эрсдэлээс сэргийлэх зорилгоор брокер, дилерийн компаниудын зайлшгүй хангах хөрөнгийн хэмжээг тогтоодог. Энэ нь тухайн брокер, дилерийн компани санхүүгийн хүндрэлийг давахад зайлшгүй шаардагдах хөрөнгийн чадварын баталгаа гаргаж, бусад оролцогчиддоо учирч болох гэнэтийн эрсдэлээс урьдчилан хамгаалах, эрсдэлийн хяналтыг бий болгож байна.

4.3. Ү н э т ц а а с н ы т ө р ө л

4.3.1. З а с г и й н г а з р ы н ү н э т ц а а с (З Г Ү Ц) б а Т ө в б а н к н ы ү н э т ц а а с (Т Б Ү Ц)

Монгол Улсын Засгийн газраас үнэт цаасыг нээлттэй болон хаалттай хэлбэрээр гаргадаг. ЗГ-аас үнэт цаасыг нээлттэй хэлбэрээр гаргахдаа богино болон дунд хугацаатай үнэт цаасыг банк болон хувийн компанид борлуулж байна.

4.3.2. А ж а х у й н н э г ж и й н х у в ь ц а а

Төвлөрсөн хадгаламжийн дансаар 2012 оны 9 дүгээр сарын байдлаар нийт 201.8 тэрбум төгрөгийн зарлагын гүйлгээ, 223.9 тэрбум төгрөгийн орлогын гүйлгээ тус тус хийгдсэн байна.

2012 оны эцсийн байдлаар “ҮЦТТТХТ”-ийн төвлөрсөн хадгаламжид 18.1 тэрбум ширхэг хувьцаа хадгалагдаж байгаа бол Монголын хөрөнгийн биржид 2.9 сая ширхэг ЗГ-ын бонд бүртгэлтэй байна.

4.4. Ү н э т ц а а с н ы а р и л ж а а б а ү р д ү н г и й н т о о ц о о л о л

4.4.1. З а с г и й н г а з р ы н ү н э т ц а а с

Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2012 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 217/А161 тоотоор хамтран баталсан “Засгийн газрын үнэт цаас гаргах, арилжаалах

журам”-ын дагуу ЗГ-аас гаргасан богино хугацаат үнэт цаас болон бондын арилжаа хийгддэг.

4.4.2. Төв банкны үнэт цаас

Төв банк нь хугацаа, хүү, арилжаалагдах нөхцөл, хэлбэрээрээ харилцан адилгүй үнэт цаасыг дотоодын банк хоорондын зах зээл дээр арилжаалж байна. ТБҮЦ нь 1 ба 4 долоо хоногийн хугацаатай гэсэн үндсэн 2 хэлбэртэй байдаг.

Тогтмол хүүтэй, борлогдох хэмжээ нь хязгаарлагтгүй хэрэгслийг 2007 онд зах зээлд нэвтрүүлсэн. ТБҮЦ-ны хүүг зах зээлийн зарчимд илүү нийцтэй болгох, төгрөг болон валютын захын өгөөжийн тэнцвэр тогтох боломжийг бүрдүүлэх зорилгоор 2010 оноос тодорхой интервалд хүүгээр өрсөлдүүлэх хэлбэрээр зохион байгуулж эхэлсэн.

Төв банкнаас үнэт цаасны арилжааг долоо хоногт хоёр удаа явуулж байгаа бөгөөд дотоодын зах зээлийн оролцогч нь урьдчилж санхүүжүүлэх зарчмаар оролцох боломжтой юм. Өнөөгийн байдлаар, нэг долоо хоногийн хугацаатай үнэт цаасны хүүг банк хоорондын зах дээр зарлаж борлогдох хэмжээг хязгааргүйгээр арилжиж байгаа бол 4 долоо хоногийн хугацаатай үнэт цаасыг зах зээлийн тогтоосон хүүгээр арилжиж байна.

Төв банкны үнэт цаасны арилжааг дараахь дарааллаар хийж, төлбөр тооцоог гүйцэтгэдэг:

1) ТБҮЦ-ыг гаргах тухай шийдвэрийг үндэслэн “ТБҮЦ-ны арилжааны мэдэгдэл”-ийг “Банк хоорондын цахим арилжааны систем”-ээр банкуудад хүргүүлэх,

2) МБСГ нь ТБҮЦ-ны арилжааны мэдэгдлийг арилжаа хийх өдрийн 9:30 цагт багтаан “Банк хоорондын цахим арилжааны систем”-д оруулах,

3) Монголбанкнаас зарласан хүүгийн түвшинд үнэт цаас худалдан авах саналаа банкууд арилжаа явагдах өдрийн 9:30-11:00 цагийн хооронд “Банк хоорондын цахим арилжааны систем”-ээр дамжуулан МБСГ-т ирүүлдэг,

4) Банкуудаас ирүүлсэн саналыг үндэслэн үнэт цаасны програмаар ирүүлсэн банкуудын саналыг ирүүлсэн дарааллаар баталгаажуулах замаар ТБҮЦ-ны арилжааны хуваарилалтыг хийх ба МБСГ нь 12:00 цагт ТТБГ-т “Банк хоорондын цахим арилжааны систем”-ээр гүйлгээний шийдвэрийг дамжуулснаар гүйлгээ хийгддэг байна.

4.4.3. А ж а х у й н н э г ж и й н х у в ь ц а а

Компанийн хувьцаатай холбоотой үйл ажиллагааг 3 үндсэн хэсэгт хуваана:

1. ҮЦТТТХТ-өөс зөвшөөрөл авсан эрх бүхий байгууллагаар баталгаажсан хэлцлийн дагуу хийх төлбөр тооцооны дүн ба үр дүнгийн тооцооллыг тодорхойлох,
2. Брокер дилерээс ирүүлсэн холбогдох баримтыг хүлээн авах, харилцагчийн гүйлгээг төвлөрсөн хадгаламжид бүртгэх,
3. Төлбөр тооцоотой холбоотой шимтгэл хураамж тооцох.

ҮЦТТТХТ-ийн мэдээллийн санг 2007 онд Монголын хөрөнгийн биржийн мэдээллийн сангаас тусгаарлаж, олон улсын стандартад нийцсэн шинэ “Е-төлбөр тооцоо” системийг

нэвтрүүлсэн. Энэхүү систем нь хоёр үндсэн системээс бүрдэх ба эхний дэд систем төлбөр тооцоог, харин хоёр дахь дэд систем нь хадгаламж болон хөрөнгийг бүртгэлийг тус тус хийдэг. Эдгээр дэд системүүд нь төвлөрсөн програм хангамжтай, мэдээллийн санд суурилсан. Мэдээллийн сан нь интернэт холболт ашиглаж мэдээлэл үүсгэх, харилцагчийн дансны ба үнэт цаасны төлбөр тооцооны мэдээллийг сэргээх үйлчилгээг үзүүлдэг. ҮЦТТХТ-д бүртгэлтэй аж ахуйн нэгжийн хувьцаа болон үнэт цаасыг дансны бүртгэлийн системийн дагуу хөтөлдөг бөгөөд энэ нь хувьцаа болон үнэт цаасны гүйлгээг тухайн бүртгэл системээр дамжуулан шилжүүлэх боломжийг олгодог. ЗГҮЦ болон ТБҮЦ-ны нэгэн адилаар аж ахуйн нэгжийн хувьцааны арилжааны үр дүнгийн тооцооллыг Т+3 зарчмаар гүйцэтгэдэг. Арилжаанд оролцогч талууд хүлээсэн үүргийн дагуу ҮЦТТХТ-ийн дансанд мөнгөн хөрөнгийг байршуулсны дагуу үнэт цаас ба мөнгөн хөрөнгийг зэрэг шилжүүлж байна.

5. ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭ

Манай орны эдийн засгийн өсөлтийг дэмжих, мөнгөний эргэлтийг хурдасгах, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад төлбөр тооцооны системийн тасралтгүй, найдвартай ажиллагаа зайлшгүй юм.

Иймд, санхүүгийн цогц үйлчилгээг иргэн бүрт, үр өгөөжтэй, найдвартай хүргэх төлбөрийн системийн шинэчлэлийг хэрэгжүүлнэ. Уг ажлын хүрээнд бэлэн бус төлбөр тооцооны чип, соронзон тууз, зайнаас хандах технологи хосолсон карт гаргах, үндэсний брэнд “₮ карт” дээр тулгуурлан төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх боломжийг өргөтгөх, гар утастай холбох, иргэний ухаалаг үнэмлэхийг төлбөр тооцоонд ашиглах, интернэтийн орчинд төлбөр хийх боломжийг боловсронгуй болгох ба хөдөлгөөнт банкны үйлчилгээний нэгдсэн системийг нэвтрүүлнэ. Ингэснээр бэлэн бус төлбөр тооцооны хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Монголбанкны санаачилгаар Азийн хөгжлийн банктай хамтран мобайл банкны эрх зүйн орчинг төлөвшүүлэх зорилгоор “Хувьсан шинэчлэгдэх дэвшилтэд мобайл банкны үйлчилгээ” төслийг хэрэгжүүлж байна. Энэхүү төслийн хүрээнд Хөдөлгөөнт банкны үйлчилгээ, цахим мөнгөний талаар баримтлах бодлогыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран баталсан. Уг бодлогод хөдөлгөөнт банкны үйлчилгээ, цахим мөнгөний үйлчилгээ үзүүлэхэд банк, ББСБ, үүрэн холбооны операторуудын оролцоо, тэдгээрийн хүлээх үүргийг тодорхой тусгасан нь мөнгөн хөрөнгийг солилцох үр ашигтай, найдвартай бүтцийг хөгжүүлэх, технологийн дэвлийг ашиглан банкны үйлчилгээнд бүрэн хамрагдах боломж хязгаарлагдмал хөдөө, орон нутгийн иргэдэд банк, санхүүгийн бүх төрлийн үйлчилгээг шуурхай хүргэж, улмаар бэлэн мөнгөний хэрэглээг багасгаж, бэлэн бус төлбөр тооцоог нийтийн хэрэглээ болгох Төв банкны бодлогод нийцсэн зохицуулалт байлаа.

Мөн Хөдөлгөөнт банкны үйлчилгээ, цахим мөнгөний талаар баримтлах бодлогын хүрээнд Монголбанкнаас холбогдох журмыг батлуулж, нийт үйлчилгээ үзүүлэгч банкуудад мөрдөн ажиллуулахаар төлөвлөж байна.

Цаашид Төв банк нь олон улсад нийтлэг мөрдөж буй Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн зарчмуудтай уялдуулан эрсдэлийн удирдлагыг бэхжүүлэх, хяналтыг сайжруулах, үнэт цаасны төлбөр тооцоо, гадаад валют болон хил дамнасан төлбөр тооцооны системийг хөгжүүлэх, эрх бүхий төрийн байгууллагуудтай хамтран ажиллах замаар санхүүгийн салбарын дэд бүтцийн тогтвортой байдлыг дэмжих, үр ашигтай найдвартай, тасралтгүй ажиллагааг хангах, бэлэн бус төлбөр тооцоог хөгжүүлэхээр ажиллаж байна.

ТӨЛБӨР ТООЦОО, БҮРТГЭЛИЙН ГАЗАР